САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ДОРЖСҮРЭНГИЙН БАТДУЛАМЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчин, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.**Хяналтын чиглэлийн 6 хяналтын хуудсыг шинэчлэн, 1 хяналтын хуудсыг шинээр боловсруулж батлуулна. | Батлуулсан хяналтын хуудасны тоо | ЭМС-ын 2024 оны А/76 тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаалаар 7 хяналтын хуудас батлуулсан байна. | ЭМС-ын 2025 оны А/26 дугаар тушаалаар халдвар судлалын хяналтын чиглэлээр ашиглах 6 хяналтын хуудсыг шинэчилж, 1 хяналтын хуудсыг шинээр боловсруулж, батлуулан хяналт шалгалтад ашиглаж байна. | 01-02 сар | 100% |
| 2. | **Арга хэмжээ 1.2**.Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/309 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж батлуулна. (ЭМЯ-ны төлөвлөгөөний 179) | Батлагдсан тушаал | ЭМС-ын 2024 оны А/309 дүгээр тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | 1, 6 дугаар хавсралтад 2 зүйл, 12 заалтыг шинээр, 32 заалтыг шинэчилж, 7 дугаар хавсралтыг шинээр боловсруулж, ЭМС-ын 2025 оны 05 дугаар сарын 01-ний А/168 дугаар тушаалаар батлуулсан. | 02-06 сар | 100% |
| 3. | **Арга хэмжээ 1.3**.Дархлаажуулалтын тухай, Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийнэ. ((ЭМЯ-ны төлөвлөгөөний 51) | Үнэлгээний тайлан | - | Ажлын хэсгийн удирдамжийн дагуу ажилласан байна. | Ажлын хэсэгт ажиллаж, үнэлгээний аргачлалыг боловсруулж батлуулан, өөрийн хариуцдаг чиглэлээр хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг сүүлийн 4 жилээр гаргаж ажиллаж байна. | 02-06 сар | 100% |
| **Зорилт 2. Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан хяналт шалгалтын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 4. | **Арга хэмжээ 2.1.**Улсын хэмжээнд 341 эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар | Хяналт шалгалтын нэгдсэн | 2024 оны нэгдсэн танилцуул- | ЭМС-ын 2024 оны А/496 дугаар | - Улсын хэмжээнд эхний хагас жилд 277 эмнэлэгт төлөвлөгөөт шалгалт хийхээс 236 эмнэлэгт | 02-06 сар | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгааллын дэглэмд төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулна. | танилцуулга | га | тушаалаар зарласан эмнэлгүүдэд хяналт шалгалт хийсэн байна. | хийж, хамралт 85 хувьтай байна.<br>Нийслэлд улаанбурханы дэгдэлттэй холбоотой төлөвлөгөөт бус шалгалт, тусгай зөвшөөрлийн сунгалт, шинээр олгох, хаяг байршил солих хүсэлтийн дагуу ажиллах болсон, унаа машины хүрэлцээгүй, 1 байцаагч ажлаасаа гарсан зэргээс шалтгаалаад 12 эмнэлэг, 3 аймагт уул уурхайн хордлогот халдвар, эмнэлгийн бүтэц өөрчлөгдөх, засвар хийгдэх зэрэг шалтгаанаар хугацаа хойшилсон 14 эмнэлэг, 8 аймагт 6 сард шалгаж дуусгах 13 эмнэлэг байна.<br>Шалгалтад хамрагдсан 236 эмнэлгийг хяналтын хуудсаар үнэлэхэд 79 буюу 34 хувь нь “бага”, 123 буюу 52 хувь нь “дунд”, 34 буюу 14 хувь нь “их” эрсдэлтэй үнэлэгдсэн байна. | | |
| | | | | | Хяналт шалгалтын явцад давхардсан тоогоор нийт 4356 зөрчил, дутагдал илрүүлж, 21 хувь (915)-ийг газар дээр нь арилгуулж, ажилласан.<br>Нийт 1823 дээж (хоол 68, ус 56, агаар 242, халдваргүйжүүлэх бодис 21, ариун материал 181, өрмийн ус 4, арчдас 1251) авч шинжлүүлснээс хоолны дээжийн 6.4 хувь буюу 117 (хоолны 4%, усны 23%, ариун материалын 7%, арчдасны 8%, агаарын 10%, халдваргүйжүүлэх бодисын 29%) нь эрүүл ахуйн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлага хангахгүй гарчээ.<br>Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор 182 эмнэлэгт 2878 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, хялбаршуулсан журмаар 30 ААН, иргэнд 52500000 (тавин хоёр сая таван зуун мянган) төгрөгийн шийтгэвэр ногдуулж, барагдуулсан.<br>- СХГ-аас Дорнод, Өмнөговь аймагт төлөвлөсөн 9, Улаанбаатарт 1 (ХСҮТ) нийт 10 эмнэлэгт хяналт шалгалт хийхэд 100 хувь "дунд" эрсдэлтэй үнэлэгдэж, илэрсэн дутагдлыг арилгуулахаар 279 заалттай 9 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгсөн.<br>Хяналт шалгалт үргэлжилж байна. | | |
| | | Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр | 1 | | Өмнөговь аймгийн 5 эрүүл мэндийн байгууллагад хийсэн төлөвлөгөөт шалгалтын дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр хэлэлцүүлж, ЭТБГ, СТГ, НЭМБГ, Өмнөговь аймгийн ЭМГ-тай холбоотой гарсан 5 шийдвэрийг дээрх газруудад хүргүүлсэн. | 03-04 сар | 100% |
| 5. | **Арга хэмжээ 2.2.**Эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт хийнэ. | Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | 2019 оны танилцуул-га | 9 дүгээр сард хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гарсан байна. | Улсын хэмжээнд 125 эмнэлэгт урьдчилан сэргийлэх шалгалт хийхээс 84 эмнэлэг хамрагдаж, хяналт шалгалт 67 хувьтай үргэлжилж байна.<br>Шалгалтын явцад 390 зөрчил илрүүлж, 105 (27%)-ыг газар дээр нь арилгуулан, 54 эмнэлэгт 342 | 02-06 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | заалттай албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, 6 байгууллага, албан тушаалтанд хялбаршуулсан журмаар 7500000 (долоон сая таван зуун мянган) төгрөгийн шийтгэвэр оногдуулж барагдуулсан байна. Хяналт шалгалтыг лабораторийн шинжилгээтэй хийж, үйл ажиллагааны 16, бүтээгдэхүүний 3, ажлын байрны 3 нийт 22 дүгнэлт гаргасан.<br>Хяналт шалгалт үргэлжилж байна. | | |
| 6. | **Арга хэмжээ 2.3.** Хүүхэд, өсвөр үеийн кабинетийн үзүүлж буй тусламж үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт хийнэ. | Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | - | 9 дүгээр сард хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гарсан байна. | Шалгалтад нийт 36 эмнэлэг (хагас жилд 24) хамруулахаар төлөвлөж, 100<br>хувьтай буюу 27 эмнэлэгт урьдчилан сэргийлэх шалгалт хийгдсэн. Үүнээс 6 аймгийн 6 эмнэлэгт хүүхэд өсвөр үеийн кабинтет ажиллахгүй байна. Үйл ажиллагаа явуулж буй 13 эмнэлгийн 6 (46%) нь өсвөр үеийнхэнд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулдаггүй, 8 (62%) нь кабинетын ХСХ-ын ажилтан томилоогүй, 4 (31%) нь үлэгийн болон зөвлөгөө өгөх өрөөгүй, 9(69%) нь өдрийн эмчилгээний өрөөгүй, 2 (15%) нь эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчид хэрэглэх амны хаалтгүй зэрэг 215 зөрчил илэрч 23 хувь (49)-ийг арилгуулан, 20 эмнэлэгт 183 заалттай албан шаардлага өгсөн байна.<br>Хяналт шалгалт үргэлжилж | 02-06 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. | | |
| 7. | **Арга хэмжээ 2.4.**Иргэн, ААН, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ. | Хяналт шалгалтын танилцуулга | 2024 оны танилцуул-га | Хяналт шалгалт бүрээр танилцуулга гарсан байна | Улсын хэмжээнд 5 аймаг, нийслэлд 16 ААН, иргэний хүсэлт, 1 аймгийн ЗД-ын шийдвэрээр 30 эрүүл мэндийн байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдэж, 28 заалт бүхий 1 албан шаардлага, 14 ЭБАТ-ны албан даалгаврыг хугацаатай хүргүүлж биелэлтийг хангуулж, 5 дүгнэлт гаргасан. 15 эмнэлэгт хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэж, 21000000 (хорин нэгэн сая) төгрөгийн торгууль оногдуулж, барагдуулалт 35 хувьтай байна.<br>СХГ (өөрт)-т иргэнээс Хүрээ амаржих газрын эдэлбэр газарт барилга байгууламж барьснаас шалтгаалж эрүүл мэндийн байгууллагын стандарт, халдвар хамгааллын дэглэм зөрчигдөж буй асуудлаар иргүүлсэн гомдлыг шалгаж, Нийслэлийн Засаг даргад “Асуудал шийдвэрлүүлэх тухай” 2025.04.02-ны 2/1553, иргэнд 2/09-ө дугаартай албан бичиг тус тус хүргүүлж шийдвэрлэсэн. Шийдвэрлээгүй хүсэлт байхгүй. | 01-06 сар | 100% |
| 8. | **Арга хэмжээ 2.5.**Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 165 эмнэлэгт дотоод хяналтыг нэвтрүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтыг нэгтгэнэ. | Сургалтын тайлан | - | 12 сард сургалтын нэгдсэн тайлан гарсан байна. | - Эхний хагас жилд төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан 236 эмнэлгийн 57 хувь буюу 135 эмнэлгийн 1774 хүнд хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга зам | 02-06 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар байгууллагын сургалт хийж ажилласан байна.<br>- СХГ-аас Дорнод, Өмнөговь аймагт төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн 9 эмнэлгийн 121 хүнд дотоод хяналтыг төлөвшүүлэх, тогтмолжуулах чиглэлээр сургалт мэдээлэл хийж ажилласан. | | |
| **ЗОРИЛТ 3. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 9. | **Арга хэмжээ 3.1.**Эрүүл мэндийн байгууллагын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл ахуйн дүгнэлт гаргана. | Нэгдсэн танилцуулга | 2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуул-га | Хагас жилийн танилцуулга гарсан байна. | Улсын хэмжээнд 7 аймаг, нийслэлд 14 ААН-ийн хүсэлтээр эрүүл мэндийн байгууллагын 14 зураг төсөл хянаж, 10 (71%)-т нь эрүүл ахуйн шаардлага хангасан дүгнэлт гаргаж, 3 барилга техникийн нөхцөл аваагүй, 1 барилга баригдаж дууссан байсан тул албан бичгээр зураг төслийг буцаасан. СХД-ийн ЗДТГ-ын захиалгаар СХД-ийн 37 дугаар хороонд баригдах хороо, ӨЭМТ, цагдаагийн цогцолбор барилга зураг төслөө хянуулаагүй барилгын ажил эхэлсэн байсан тул ЗТХ-ийн 6.17.2-т заасны дагуу 2500.0 төгрөгөөр торгосон.<br>2 аймагт барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах 4 комиссын бүрэлдэхүүнд ажиллан, 3 (72%) барилгыг саналын хуудсаар үүрэг өгч, 1 барилгыг шууд ашиглалтад хүлээн авсан.<br>СХГ-т эмнэлгийн барилгын зураг төсөл хянуулах хүсэлт ирээгүй. | 01-06 сар | 100% |
| 10. | **Арга хэмжээ 3.2.**Хүний эрүүл | Шийдвэрлэл- | 100% | 100% | Эрүүл ахуйн тухай хуулийн 8 | 01-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй, өндөр эрсдэлтэй мал, амьтны гаралтайгаас бусад түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлох, импортлоход эрүүл ахуйн дүгнэлт гаргана. | тийн хувь | | | дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу 4 ААН, 1 байгууллагын цусны ийлдэс, цусны сийвэн, шээсний сорьцыг АНУ, БНСУ, ХБНГУ, Хонконг улс руу илгээх 48 хүсэлтээр **48 дүгнэлт** гаргасан. Үүнд: Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагын ХБНГУ руу допингийн шинжилгээний зорилгоор илгээх шээсний сорьцны 24 дүгнэлт, Ливэр центр ХХК-ий АНУ руу судалгааны зорилгоор илгээх цус, шээс, сийвэнгийн 5 дүгнэлт, Реженератив медикал сентр ХХК-ий хромосомын өөрчлөлт, ургийн хүйсийг эрт хугацаанд тодорхойлох шинжилгээний зорилгоор БНСУ руу илгээх цусны 15 дүгнэлт, ХӨСҮТ-ийн баталгаажуулалтын зорилгоор БНСУ, Хонконг улс руу илгээх хамрын арчдас, сийвэнгийн 3 дүгнэлт, Си Эль ДабльЮ ХХК-ийн шинжилгээний зорилгоор БНСУ руу илгээх сорьцны 1 дүгнэлт байна. | сар | |
| **Зорилт 4. Орон нутаг дахь улсын /ахлах/ байцаагчдыг бодлого, удирдлага, мэргэжил арга зүй, зөвлөмжөөр хангана.** | | | | | | | |
| 11. | **Арга хэмжээ 4.1.**Хэрэгцээний үнэлгээнд үндэслэн орон нутаг дахь хяналтын чиглэлийн улсын байцаагчдыг чадавхижуулах давтан сургалтыг зохион байгуулна. | Сургалтын тайлан | 2 | | Хугацаа болоогүй.<br>Бэлтгэл ажлын хүрээнд ДЭМБ, НЭМҮТ-тэй хамтран сургалт хийхээр холбогдох мэргэжилтнүүдтэй 2 удаагийн уулзалт хийж, 10 дугаар сард хийхээр төлөвлөж байна. | 05-12 сар | - |
| 12. | **Арга хэмжээ 4.2.**Улсын байцаагчдад зориулсан хяналт шалгалтын эрх зүйн баримт бичгийг эмхэтгэж, гарын авлага | Гарын авлага | - | Гарын авлага гаргаж, хүргүүлсэн | Улсын байцаагчдад зориулан Засгийн газрын 6 тогтоолоор батлагдсан 5 журам, Сайдын 6 тушаалаар батлагдсан 10 журам, | Гарын авлага гаргасан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргана. | | | байна. | нийт 15 эрх зүйн баримт бичгийг эмхэтгэн, 60ш хэвлүүлж, шинээр эрх авсан улсын байцаагчдад тарааж байна. | | |

**Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.**Мэргэжлийн болон хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой сургалт, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх сургалтад хамрагдана. | Гэрчилгээ | - | 1 | Монголын тархвар/халдвар судлаач эмч нарын нийгэмлэгээс зохион байгуулсан “Халдвар хяналтын ажилтан” 2кр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. | 05.01-05.02 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 2.**Эрх зүйч мэргэжлээр баклаврын эчнээ сургалтыг төгсөнө. | Гэрчилгээ | - | 1 | Улаанбаатар Эрдэм их сургуулийг “эрх зүйч” мэргэжлээр суралцаж төгссөн. | 2023.02. 2025.02 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч ........................................./Д.Батдулам/ 2025.06.10
(*Албан тушаал*) (*Нэр, гарын үсэг*) (*Огноо*)